

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/03/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батсайхан Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhans@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11



УВС АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ч.ЧИМЭД ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.03.18 № УВА-2022/234/НА-СТА-ЭГТС
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.БАТСУУРЬ

0200200610

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,948,968.39	251,455,076.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,948,968.39	251,455,076.39
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,948,968.39	251,455,076.39
31210	Төгрөг	8,948,968.39	251,455,076.39
31211	Төрийн сангийн харилцах	8,948,968.39	251,455,076.39
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,948,968.39	251,455,076.39
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,948,968.39	251,455,076.39
51	Засгийн газрын хувь оролцоо	8,948,968.39	251,455,076.39
51200	Хуримтлагдсан үр дүн	8,948,968.39	251,455,076.39
51210	Өмнөх үеийн үр дүн	68,013,417.39	8,948,968.39
51220	Тайлант үеийн үр дүн	-59,064,449.00	242,506,108.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,948,968.39	251,455,076.39

2.2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,885,149,800.00	4,691,150,651.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,500.00	176,050,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,500.00	176,050,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,500.00	176,050,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,500.00	176,050,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,885,090,300.00	4,515,099,901.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,885,090,300.00	4,515,099,901.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,885,090,300.00	4,515,099,901.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,885,149,800.00	4,691,150,651.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,944,214,249.00	4,448,644,543.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	2,944,214,249.00	4,448,644,543.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-59,064,449.00	242,506,108.00

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,885,149,800.00	4,691,150,651.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,500.00	176,050,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,500.00	176,050,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,500.00	176,050,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,500.00	176,050,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,885,090,300.00	4,515,099,901.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,885,090,300.00	4,515,099,901.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,885,090,300.00	4,515,099,901.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,885,149,800.00	4,691,150,651.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,944,214,249.00	4,448,644,543.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,944,214,249.00	4,448,644,543.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,944,214,249.00	4,448,644,543.00
223001	Бусад хөрөнгө	2,944,214,249.00	4,448,644,543.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	2,944,214,249.00	-4,448,644,543.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-59,064,449.00	242,506,108.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,013,417.39	8,948,968.39
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,948,968.39	251,455,076.39

2.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			68,013,417.39	00.00	68,013,417.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	00.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			68,013,417.39	00.00	68,013,417.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			0.00	00.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			0.00	00.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00	00.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт			0.00	00.00	0.00
Зарласан ногдол ашиг			0.00	00.00	0.00
Тайлант үеийн үр дүн			-59,064,449.00	00.00	-59,064,449.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			8,948,968.39		8,948,968.39
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			8,948,968.39	00.00	8,948,968.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	00.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			8,948,968.39	00.00	8,948,968.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			0.00	00.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			0.00	00.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00	00.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт			0.00	00.00	0.00
Зарласан ногдол ашиг			0.00		0.00
Тайлант үеийн үр дүн			242,506,108.00		242,506,108.00
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			251,455,076.39		251,455,076.39

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,659,762,200.0	4,448,644,543.0	4,448,644,543.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,659,762,200.0	4,448,644,543.0	4,448,644,543.0	0.0
223001	Бусад хөрөнгө	4,659,762,200.0	4,448,644,543.0	4,448,644,543.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,659,762,200.0	4,691,150,651.0	4,691,150,651.0	0.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,515,099,800.0	4,515,099,901.0	0.0	4,515,099,901.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,515,099,800.0	4,515,099,901.0	0.0	4,515,099,901.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	4,515,099,901.0	-4,515,099,901.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	0.0	4,515,099,901.0	-4,515,099,901.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	144,662,400.0	176,050,750.0	176,050,750.0	0.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	176,050,750.0	176,050,750.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	144,662,400.0	0.0	0.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	8,948,968.4	0.0	8,948,968.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	251,455,076.4	0.0	251,455,076.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 7/384 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь орон нутгийн иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах, иргэдийн аж байдалд эерэг таатай нөлөөлөл бий болгох, ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,448.6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 22.2 сая төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар тооцож 17.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 242.5 сая төгрөгөөр буюу 96 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8.9	251.4	242.5
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа			
Бараа материал	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	0.00	0.00	0.00
Нийт хөрөнгө	8.9	251.4	242.5
Өр төлбөр	0	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8.9	251.4	242.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8.9	251.4	242.5

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 251.4 сая төгрөг болж, 242.5 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 251.4 сая төгрөг болж, 242.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүн ашигтай гарснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,806.0 сая төгрөгөөр буюу 38.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,504.4 сая төгрөгөөр буюу 33.8 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуулийн тогтоомжид заасны дагуу тооцож төлөвлөдөг.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг 4,659.8 сая төгрөгийн төсөв баталснаас 4,515.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 144.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,515.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 176.0 сая төгрөг, нийт 4,691.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, хөрөнгийн зардалд 4,448.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,448.6 сая төгрөг буюу 95.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хувьд Тайлант хугацаанд зарлагын гүйлгээ гараагүй тул шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ОНХС										
	ДҮН										

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /С.БАТСАЙХАН/

2022 оны 03 сарын 14-ний өдөр